

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

Гаалийн байгууллага нь хүний нөөцийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус боловсруулан 2014 оны А/144 тоот тушаалаар баталсан.

Хүний нөөцийн зөв бодлого хэрэгжүүлэх, мэдлэг чадвартай, гадаад дотоод орчны өөрчлөлтөд уян хатан зохицож чадах хүний нөөцийг бий болгох, гаальчдыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, төрийн үйлчилгээг иргэдэд чанартай үзүүлэх үүрэг, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн зорилгыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүний нөөцийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр:

1. Гаалийн улсын байцаагчийг сэлгэн ажиллуулах журмыг шинээр боловсруулан батлуулж, 2015 онд өөрчлөлт оруулан мөрдөн ажиллаж байна.
2. Гаалийн улсын байцаагчид цол, түүний нэмэгдэл олгох тухай журамд нэмэлт өөрчлөлт оруулан боловсруулаад байна.

Гаалийн ажилтан нарын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

1. Шивээхүрэн дэх гаалийн газарт 32 айлын орон сууцыг барьж, ашиглалтад оруулахад бэлэн болгосон.
2. ГЕГ-ын ажлын байрыг засаж, тохижуулан ажиллах нөхцөлийг сайжруулсан.
3. 2015 оны эхний хагас жилд гаалийн системийн хэмжээнд нийт 26 хүнд 6,5280000 төгрөгийн буцалтгүй тусламж өгсөн байна.

Гаалийн улсын байцаагчийг сургаж, хөгжүүлэх бодлого, чиглэлээр:

1. Удирдлагын академийн Төрийн удирдлагын мэргэшүүлэх сургалт, магистрын тэтгэлэгт сургалтад нийт 3 гаалийн байцаагч суралцаж байна.
2. Дотоодын их дээд сургуулийн докторантурын сургалтад 2 гаалийн байцаагч, өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрийн сургалтад 3 гаалийн байцаагч тэтгэлэгтэйгээр суралцаж байна.
3. ДГБ, олон улсын байгууллага, гадаад улсын гаалийн байгууллагаас зохион байгуулсан сургалтад 2015 оны эхний хагас жилийн байдлаар 57 гаалийн байцаагч хамрагдаад байна.

Хүний нөөцийн эрсдэлийг тооцож ажиллах чиглэлээр :

1. Гаалийн байгууллагын хэмжээнд дутагдалтай байгаа орон тооны судалгааг хийж, ГСГГ, ШХГГ, ДОГГ-ын дутуу орон тоог нөхсөн.
2. Гаалийн байгууллагад ажиллаж байгаа гаалийн байцаагч нарын мэргэжлийн судалгааг хийж, шаардлагатай мэргэжилтэй ажилтанг нөөцөөс бүрдүүлэн авч ажиллуулж байна.
3. Гаалийн ажилтны бүтээлч ажиллагааг дэмжих зорилгоор 2015 оны эхний хагас жилийн байдлаар нийт 107 ажилтан албан хаагчдийг төрийн дээд одон медаль, цол болон байгууллагын шагналаар шагнасан.
4. Гаалийн байгууллагын хүний нөөцийн програмыг шинээр боловсруулан, ажиллаж байна.

Байгууллагын дотоод соёлыг төлөвшүүлэх чиглэлээр:

1. Гаалийн байгууллагад шинээр ажилд орох болон 1 гаалийн байгууллагаас нөгөө гаалийн байгууллагад ажиллахаар томилогдсон ажилтанг дадлагжуулах, шинэ орчинд дасан зохицох боломжийг хангах зорилгоор Гаалийн байгууллагын хүний нөөцийн хөтөлбөрийн дэд хөтөлбөр болох “Дадлагажуулах ” хөтөлбөрийг боловсруулан, мөрдөн ажиллаж байна.
2. Байгууллагын албан хаагчдыг ажилдаа идэвх сонирхолтой, найрсаг, бие биенээ гэсэн сэтгэлтэй хамт олонч уур амьсгалыг бий болгох, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Гаалийн цом-2015” спортын арга хэмжээ, “Нэг зорилго, нэг хамт олон” сэдэвт аялалыг зохион байгуулсан.